5. Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаа уялдаа холбоог сайжруулах.

6. Хилийн тагнуулын албыг буцаан хил хамгаалах байгууллагад шилжүүлэх.

**Б. Түвшинтулга** - *Хууль сахиулахын уйирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, ахмад*

## УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТӨРӨЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй:*** *Энэхүү илтгэлээр улсын хил хамгаалалтын төрлийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох зарим асуудлыг онолын хувьд судлаж, улсын хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлохыг хүслээ.*

***Түлхүүр** үг: Улсын хил хамгаалалт, улсын хил хамгаалалтын төрөл, онцгой нөхцөл байдал үүссэн үеийн хил хамгаалалт*

Манай улс нь ОХУ болон БНХАУ-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд хүч хэрэглэхгүй, хүчээр сүрдүүлэхгүй байх. харилцан үл довтлох гэсэн хэдий ч дэлхийн улс орнуудын дунд эдийн засгийн болон газар нутаг, шашин шүтлэгийн үзэл баримтлалын сөргөлдөөн өдрөөс өдөрт хурцдаж, улс хоорондын зөрчил нь хүрээгээ тэлж, тив хоорондын зөрчил зөрөлдөөн болон хувирч байна[1].

Дэлхий ертөнцөд даяарчлалын нөлөөгөөр гарч буй олон өөрчлөлтүүд болох хил дамнасан гэмт үйлдэл, нийгэм эдийн засгийн хямрал. байгаль экологийн өөрчлөлт. хүн амын амьжиргааны түвшингийн доройтол, хялбар аргаар мөнгө олох хууль бус ажиллагаа, хязгаар нутгаас төв рүү чиглэсэн нүүдэл зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хурцаар илрэх болов. Улсын хилээр мансууруулах бодис, зэвсгийн наймаа хийх, зохион байгуулалттай бүлгийн үйл ажиллагаа идэвхжих зэрэг нь хил хамгаалах байгууллагын албаны үйл ажиллагааг шинэ нөхцөл байдалд, шинэлэг арга хэлбэрүүдээр, эрчимтэй, далайцтай явуулахыг шаардаж байна.

Ийм нөхцөл байдал нь эдийн засгийн хувьд сул дорой манай улсад сөргөөр нөлөөлж болох юм. Улс орны улс төрийн тогтворгүй байдал нь улсын хил хамгаалалтад сөргөөр нөлөөлж, хил хамгаалалтын төрлийг нэмэгдүүлж, боловсронгуй болгох зайлшгүй шаардлага урган гарч байна.

Өнөөгийн байдлаар хил хамгаалах байгууллага нь:

> Ердийн.

[1] Монгол Улс БНХАУ хооронд байгуулсан гэрээ. 2002.

> Хүч нэмэгдүүлсэн.

> Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн улсын хил хамгаалалт гэсэн 3 хэлбэрээр улсын хил хамгаалалтаа зохион байгуулж байна[1].

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах. Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт[1 2] гэнэ.

**Ердийн үеийн улсын хил хамгаалалт нь** орон тооны хүч хэрэгслийг өдөр тутмын тогтоосон горимоор ажиллуулах боломж бүхий улсын хил хамгаалалтын нэгэн төрөл.

**Хүч нэмэгдүүлсэн үеийн улсын хил хамгаалалт нь** хилийн цагийн байдал хүндэрсэн үед хүч хэрэгслийг идвэхитэй ашиглаж албаны ачаалал, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, онцгой тохиолдолд ХЗ, харуулыг нэмж байгуулах,хамгаалах хэсгийг дахин хуваарилж тодотгох арга хэмжээг хэлнэ.

**Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн улсын хил хамгаалалт нь** тодорхой нутаг дэвсгэрт осол, байгалийн аюулт үзэгдэл, сүйрэл, байгалийн гамшгийн улмаас хүний амь нас үрэгдэх, хүмүүсийн эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчинд гэм хор учруулах. материалын үлэмж хохирол бий болсон үеийн хамгаалалтыг хэлнэ тайлбарлаж өгсөн байдаг[3].

Харин цэргийн шинжлэх ухааны доктор, профессор хурандаа Н.Наранжамц Бүс нутаг- хил хамгаалалт үзэл баримтлал номондоо улсын хил хамгаалалтын төрлийг доорх байдлаар тодорхойлсон байна.

Сүүлийн үеийн улс орнуудын дунд үүсэж буй цэрэг улс төрийн байдал хурцадаж, дүрвэгсдийн тоо жилээс жилд нэмэгдэж байна. Манай урд хөршийн дотоод зөрчил зөрөлдөөн сүүлийн үед эрс нэмэгдэж байна. Ийм нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалалтаа өнөөгийн байдлаар зохион байгуулах нь хангалтгүй хэмээн үзэж цэрэг улс төрийн байдал хурцатсан үеийн улсын хил хамгаалтыг онолын хувьд судлан боловсруулах, шаардлагатай байна.

[1] Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм. 2007.
[2] Хилийн тухай хууль 2017.
[3] Хилчний тайлбар толь 1998.

Улсын хилийг манах гэдэг нь: Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн дэглэм сахиулах, хилийн асуудлыг зохицуулахаар хилийн төлөөлөгч хил хамгаалах байгууллагаас явуулж буй ажиллагаа;

Улсын хилийг сэргийлэн хамгаалах гэдэг нь: Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрт Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхолд халдсан үйлдлийг илрүүлэн, таслан зогсоох. хилийн төлөөлөгчийн байгууллага зохицуулах болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн засаг захиргаатай хамтран хил орчмын дэглэм сахиулах үйл ажиллагаа;

Улсын хилийг хориглон хамгаалах гэдэг нь: Улсын хил дээрх зэвсэгт халдлагыг няцаах болон хил халхалтын нэгдсэн бодлогын дагуу хил хамгаалах байгууллагаас явуулах үйл ажиллагааг хэлнэ.

Энэ ойлголтоор улсын хилийг манах, сэргийлэн хамгаалах үйл ажиллагаа нь улсын хил хязгаарын аюулгүй байдлын гол суурь ухагдахуун бөгөөд улсын хилийг хориглон хамгаалах үйл ажиллагаа нь “ дайн бүхий болон дайн”-ы үеийн улсын хил халхалтын хүрээнд явагдах цэрэг-дайны ажиллагаа бөгөөд цаг үеийн шинжтэй ухагдахуун гэж үзэж байна. Улсын хил хамгаалалт нь улсын хил манах, сэргийлэн хамгаалах, хориглон хамгаалах гэсэн төрөлд хуваагдснаар түүний цэргийн мэргэжлийн болон засаг захиргааны удирдлага, хангалт нь боловсронгуй болох зүй тогтолтойг улсын хил хамгааглалтын түүхэн уламжлал болон цаг үеийн шаардлага харуулж байна.

Сүүлийн үеийн улс орнуудын дунд үүсэж буй цэрэг улс төрийн байдал хурцадаж, дүрвэгсдийн тоо жилээс жилд нэмэгдэж байна. Манай урд хөршийн дотоод зөрчил зөрөлдөөн сүүлийн үед эрс нэмэгдэж байна. Ийм нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалалтаа өнөөгийн байдлаар зохион байгуулах нь хангалтгүй хэмээн үзэж цэрэг улс төрийн байдал хурцатсан үеийн улсын хил хамгаалтыг онолын хувьд судлан боловсруулах, шаардлагатай байна.

Монгол улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал улсын хилийн халдашгүй дархан байдал, улсын хил хамгаалалтад сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлсийг доорх байдлаар томъёолсон байна.

А. Шууд нөлөөлөх орчин нь:

1. Физик газар зүйн орчин
2. Байгаль экологи
3. Хил орчмын нутаг дэвсгэр дэхь хөгжил, аж байдал
4. Эсрэг тэсрэг талуудын хүчний харьцаа

5. Хилийн орон зай дахь сөргөлдөгч талуудын үйл ажиллагааны төрөл, хэлбэр. давтамж

Б. Шууд бус, дам нөлөөлөх орчин нь:

1. Улс төр. нийгэм-эдийн засгийн

3. Хууль эрх зүйн

4. Хил залгаа улсын харилцаа, хамтын ажиллагаа

5. Цэрэг, техникийн хүчин чадал зэрэг нь үндэсний аюулгүй байдалд нөлөөх хүчин зүйл болно[1].

Улсын хил хязгаарын нөхцөл байдал гэдэг нь тухайн бүс нутгийн түүхэн болон доторхой цаг хугацааны гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг, харин хилийн цагийн байдал гэж шийдвэр гаргах мөчид өрнөж буй үйл явцын тухай ойлголт гэж тодорхойлж болох юм. Улсын хил дээр үүссэн хилийн зөрчил даамжирвал улсын хил хязгаарт аюул үүсгэх, түүнийг саармагжуулах, хариу үйлдлийг таслан хийхгүй бол өдөөн хатгалга. зэвсэгт халдлага, улмаар зэвсэгт мөргөлдөөнд хүрэх ноцтой үр дагавар байгаа юм. Орон нутгийн төрийн байгууллага, аж ахуй нэгж, ХХТХГ, ялангуяа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хил хамгаалалтад чиглүүлсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм.

Улсын хилийг хамгаалах асуудлыг зөвхөн хилийн орон зайд хил хамгаалах байгууллагаас хэрэгжүүлдэг арга хэмжээ гэж үзэх нь учир дутагдалтай бөгөөд манайх шиг жижиг улсын хувьд олон улсын хэмжээнд улс төр, дипломатын аргаар, улс орны хэмжээнд төрийн бодлогоор зохицуулж, хилийн аюулгүй байдлаа ханган, хил хамгаалалтын арга тактик болон төрөл хэлбэрээ боловсронгуй болгох зайлшгүй шаардлага урган гарч ирж байна.

***М.Нармандах*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн*
*821 дүгээр дамжааны суралцагч, хошууч*

## ХИЛИЙН ЦЭРГИЙН УДИРДЛАГЫН ОНОЛЫН АГУУЛГА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЗАРЧИМ

***Хураангуй.*** *Хилийн цэргийн удирдлагын онол нь удирдлагын хууль, зүй тогтол, зарчим, хэлбэр, арга, удирдлагын системийн арга ажиллагаа болон хөгжлийн онцлогийн тухай шинжлэх ухааны мэдлэгийн цогц юм.*

***Түлхүүр*** *үг. Удирдлагын онол, хууль, зүй тогтол. хил хиамгаалах байгууллага, удирдлагын үндсэн зарчим.*

[1] Хил судлал сэтгүүл. 2015. №2.

Хил судлалын шинжлэх ухааны судлагдахууны бүрэлдэхүүн хэсэгт хилийн цэргийн байгуулалтын онол, хил хамгаалалтын урлагийн онол, хилийн цэргийн удирдлагын онол голлох байр эзэлдэг. Хилийн цэргийн байгуулалтын үндсэн асуудлын нэг нь цэргийн удирдлага бөгөөд түүний үндэс, зарчим, зүй тогтол, арга, зохион байгуулалт нь цэргийн болон нийгмийн шинжлэх ухааны судлагдахуунд чухал байр эзэлсээр байна[1]. Монгол оронд ардчилал, өөрчлөлт, шинэчлэлийн давалгаа ид өрнөж байсан 1990-ээд онд ямар арга барилаар яаж ажиллаж байгууллагаа хэрхэн яаж аварч, авч үлдэх, цаашид ямар арга барилаар хөгжүүлэх нь бүх шатны удирдагч нарын тулгамдсан асуудал, тулгарсан зорилт болж байлаа. Тухайн үед хил хамгаалах байгууллагын удирдлага бий болсон бодит байдлыг шийдэх “гарц"-ыг олохын тулд өнгөрсөн, одоо, ирээдүйн харилцан хамаарал, уламжлал шинэчлэлийн онол арга зүйн үндэс, шалтгаан үр дагаврыг олон талаас нь үнэлэн дүгнэж, түүнд ул суурьтай хандан хөгжил дэвшилд хүргэсэн орчин үеийн удирдахуйн шинжлэх ухааны онол арга зүйг удирдлагынхаа үндсэн чиг баримжаа болгох нь чухал юм гэдгийг ойлгож мэдэрсэн.

Орчин үеийн удирдахуйн ухааны хөгжлийн чиг хандлага, онол арга зүйд үндэслэн байгууллагаа хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж эрмэлзэх зүйл, эрхэм дээд зорилго, зорилт түүнийгээ хэрэгжүүлэх арга барилаа тодорхойлж, хүнлэг чанар, шударга ёс, үр дүнг үйл ажиллагааныхаа үндсэн зарчим болгон ирсэн.

Өмнөх үеийн түүх. өнгөрсөн үйл явдлын үр дагаврыг тал бүрээс нь нягтлан дүгнэж, аливаа шийдвэрийг гаргахдаа стратегийн хэмжээнд алсын хараатай, өргөн цар хүрээтэй сэтгэж, үйл ажиллагаагаа хамт олны сэтгэл зүй, үзэл бодлыг үндсэн үүрэг. зорилгоороо бахархах, түүнийгээ сэтгэл зүтгэл гарган биелүүлэхэд чиглүүлэн өөрчлөх нь зөв удирдлагын нэг үндэс юм. Хил хамгаалах байгууллагын одоогийн удирдлага тухайлбал хошууч генерал Ц.Сэргэлэн уламжлал, шинэчлэл, удирдлагын залгамж чанарыг хадгалан удирдахуйн онол, шинжлэх ухааны мэдлэг ололтыг дээдлэн хүнээ хөгжүүлэх, итгэл өгч бие даалгах, хил хамгаалалтын эрх зүйн орчинг талаар зорилтуудыг дэвшүүлж, шийдвэртэй арга хэмжээ авч байгаа нь чухал алхам хэмээн үзэж байна.

Монгол Улсад орчин үеийн хил хамгаалах байгууллага үүсч хөгжсөн 80 гаруй жилийн хугацаанд цэргийн шинжлэх ухааны доктор хошууч генерал П.Даш “Хил хамгаалалтын онол", цэргийн шинжлэх ухааны доктор

[1] *Ц.Цэрэндорж, С.Цэрэндамба* нар. Бидний менежмент. -УБ„ 2010. 6 дахь тал.